



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/688

Өлгий

Цэргийн жинхэнэ албаны татлага явуулах тухай

Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, Засгийн газрын 2014 оны мн/58 дугаар тогтоол, Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргын дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Сагсай, Толбо, Өлгий сумын бүх багуудын 18-27 насны цэргийн алба хаагаагүй залуучуудыг 2018 оны 10 дугаар сарын 03-ноос 10 дугаар сарын 17-ны хүртэл цэргийн жинхэнэ албаны татлаганд хамруулсугай.

2. Сумдын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

а) Цэргийн жинхэнэ албанд татагдах залуучуудыг эрхэлсэн ажлаас нь чөлөөлж, цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд бэлэн байлгах;

б) Цэрэг татлагын байр, эмч нарын үзлэгийн өрөөг шаардлагын дагуу зохион байгуулах, цэрэг татлагын бүрэлдэхүүнийг байрлуулах, хооллуулах газрыг бэлэн болгож, хоол хүнсээр хангах;

в) Цэргийн жинхэнэ албанд татагдах эрчүүдийг цахим үнэмлэх, эрүүл мэндийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, мэргэжлийн үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, 2 хувь цээж зурагтай ирүүлэх;

г) Зүрхний бичлэг, рентгенд харалт хийх, ЭХО-оор үзэх, цусны ерөнхий шинжилгээ болон бэлгийн замын халдварын шинжилгээг аймагт хийх тул 2018 оны 10 дугаар сарын 15-ны өглөө 08.00 цагт Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид бэлэн байлгах.

3. Цэргийн албанд татагдагсдад эрүүл мэндийн үзлэг хийх багаж, бичиг хэрэгсэл, эмээр хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнөөр хасагдсан залуучуудыг цаашдаа эмчлэх арга хэмжээ авч ажиллах, аймагт ирж дахин хамрагдах иргэдийн зүрхний бичлэг, рентгенд харалт хийх, ЭХО-оор үзэх, цусны ерөнхий шинжилгээ болон бэлгийн замын халдварын шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулахыг аймгийн Эрүүл мэндийн газар /С.Айгүл/, Нэгдсэн эмнэлэг /Т.Сериюжан/ нарт даалгасугай.


4. Цэрэг татлагын хугацаанд хэв журам сахиулах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар /Б.Батхүү/-т даалгасугай.

00001620


5. Цэрэг татлагын үеэр Батлан хамгаалах хууль тогтоомж болон шаардлагатай мэдээллүүдийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй нэвтрүүлж байхыг Баян-Өлгий аймгийн орон нутгийн радио, телевизийн захирал /Н.Оспан/-д даалгасугай.

6. Хугацаат цэргийн алба хааж хугацаа нь дуусч бэлтгэлээр халагдаж байгаа түрүүч, байлдагч болон цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдээс цэргийн гэрээт албанд сайн дурын үндсэн дээр элсүүлэх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб /Г.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

7. Цэрэг татлагын байранд бэлэн байх сумдын хуваарийг хавсралтаар баталсугай.



Аймгийн Засаг даргын 2018 оны
тоот захирамжийн хавсралт



1. Цэрэг татлагын хуваарь:

Өлгий сум	2018 оны 10 дугаар сарын 03-ны өдөр "Лхагва" гариг
Бугат сум	2018 оны 10 дугаар сарын 04-ний өдөр "Пүрэв" гариг
Булган сум	2018 оны 10 дугаар сарын 06-ны өдөр "Бямба" гариг
Дэлүүн сум	2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр "Даваа" гариг
Толбо сум	2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр "Мягмар" гариг
Буянт сум	2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр "Лхагва" гариг
Алтай сум	2018 оны 10 дугаар сарын 11-ний өдөр "Пүрэв" гариг
Сагсай сум	2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр "Баасан" гариг

2. 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр халагдсан дайчдыг хүлээж авах

3. 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр "Даваа" гаригт эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах тул Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид 08.00 цагт бэлэн байлгах

4. 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Зэвсэгт хүчний 340 дүгээр ангиас 08.00 цагт цэрэг ачуулах ажлыг зохион байгуулах.